

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ О.НАРАНДЭЛГЭР ТАНАА

ИЛТГЭХ ХУУДАС

“Биржээр арилжсан бараа түүхий эдийн тодорхойлолт олгох журам”-ын хэрэгжилтэд хяналт, мониторинг хийсэн тухай

2022.07.05

Дугаар.01

Улаанбаатар хот

Нэг. Хяналт, мониторингын зорилго ба цар хүрээ

1.1 Хяналт, мониторингын зорилго нь “Биржээр арилжсан бараа түүхий эдийн тодорхойлолт олгох журам”-ын хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх, хамаарах хэлтсүүдэд дотоод хяналт, шалгалт хийж журмын хэрэгжилтэд хяналт тавих, хэрхэн үр ашигтайгаар хэрэгжүүлж ямар үр нөлөөтэй ажилласанд дүгнэлт өгөх, илэрсэн алдаа дутагдлын шалтгаан нөхцлийг тогтоож, цаашид авах арга хэмжээний таолоар дүгнэлт гаргаж, зөвлөмж өгч холбогдох албан тушаалтнаар шийдвэрлүүлэхэд чиглэгдэнэ.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны А/12 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, 2022 оны А/33 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан Биржээр арилжсан бараа түүхий эдийн тодорхойлолт олгох журам, 2022 оны компанийн хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөө зэргийг тус тус үндэслэн компанийн Гүйцэтгэх захирлын баталсан 01 дүгээр удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт дотоод хяналт, мониторингын ажлыг хийж гүйцэтгэлээ.

1.2. Хяналт, мониторингын хамрах хүрээ

1. Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилт;
2. Биржээр арилжсаныг нотлох тодорхойлолт олгохтой холбоотой тодорхойлолтын хүсэлт хүлээн авах, тодорхойлолтыг олгох, дахин олгох, хүчингүй болгох,
3. Тодорхойлолтын маягт захиалж хэвлүүлэх, бүртгэх хадгалах архивт хүлээлгэн өгөх харилцаа;
4. Тодорхойлолтын хяналтын картыг үнэн зөв хөтөлж байгаа, эсэх хураамжийг цаг тухайд нь төлүүлж байгаа, эсэх;
5. Тодорхойлолтод бараа түүхий эдийн нэр төрөл, ангилал, боловсруулалт, хэмжээ болон үнийн мэдээллийг үнэн зөв тусгаж байгаа эсэх;
6. Тодорхойлолтыг журмын дагуу олгож байгаа эсэхэд хяналт хийх зорилгоор арилжааны өмнөх, арилжааны үеийн, арилжааны дараахь хяналтууд хийгдэж байгаа эсэх;
7. Биржээр арилжсан боловсруулаагүй бараа түүхий эдийн ангилал өөрчлөн тодорхойлолт олгохдоо, боловсруулсан бараа түүхий эдийн ангилалд хөрвүүлэх хувийг зөв тооцоолж байгаа эсэх;
8. Тодорхойлолтын хүчинтэй хугацааг мөрдөж байгаа эсэх;

9. Тодорхойлолтыг үндэслэн арилжааны шимтгэлийг үнэн зөв тодорхойлж байгаа эсэх;

10. Биржийн байнгын гишүүд арилжааны шимтгэлээ хугацаанд нь төлж барагдуулж байгаа эсэх;

1.3. Хяналт, мониторинг хийсэн бүрэлдэхүүн:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн О.Сайнжаргал

Төлөвлөлт, мониторингын мэргэжилтэн Х.Наранцацралт

1.4. Хяналт, мониторингод хамрагдсан хэлтэс

Бүх хэлтэс

1.5. Хяналт мониторингд хамрагдсан хугацаа

2021 оны 6 дугаар сараас 2022 оны 6 дугаар сар хүртэл

1.6. Хяналт, мониторинг хийсэн хугацаа

2022 оны 6 дугаар сарын 17-ноос 2022 оны 7 дугаар сарын 01-н хүртэл

“Биржээр арилжсан бараа түүхий эдийн тодорхойлолт олгох журам”-ын хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх ажлын хүрээнд хэлтсүүдээс гаргуулж авсан материалын жагсаалт

1. Тодорхойлолтын маягт хэвлүүлдэг хэвлэлийн компанийн материал /гэрээ,хүлээн авсан тодорхойлолтын жагсаалт
2. Дугаарласан болон арилжаанд орсон тодорхойлолтын жагсаалт,баримт
3. Устгасан болон хүчингүй болсон тодорхойлолтын жагсаалт,баримт
4. Биржээр арилжиж буй бараа, түүхий эдийн жагсаалт
5. Хяналтын карт болон тодорхойлолтын хураамж төлсөн баримт материал
6. Арилжааны хэлцэлийн жагсаалт
7. Дэнчин болон барьцаа хөрөнгийн жагсаалт баримт,харилцагчид буцаан олгосон баримт
8. Брокерын компаниудын биржийн гишүүнчлэлийн гэрээ, тусгай зөвшөөрлийн хуулбар, СЗХ-ны тогтоол
9. Агуулахтай байгуулсан итгэмжлэлийн гэрээ, агуулахын бараанд биет хяналт хийсэн материал
10. Жишиг үнэ бодсон баримт, материал
11. Төлбөр тооцооны баримт материал, гүйлгээний жагсаалт
12. Биржээр арилжсан бараа түүхий эдийн шимтгэл бодсон баримт материал
13. Тодорхойлолтын хүчинтэй хугацааг мөрдөж байгаа, эсэхийг батлах баримт материал, тодорхойлолтыг дахин олгосон баримт материал
14. Биржийн байнгын гишүүд арилжааны шимтгэлээ журамд заасан хугацаанд төлж барагдуулж байгаа, эсэхийг нотлох баримт материал

Хоёр. Хяналт, мониторингын үр дүн

Дотоод хяналт, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэхдээ 2021 оны 6 дугаар сарын 01-ээс 2022 оны 6 дугаар сарыг дуустал хугацааг хамааруулан хийж гүйцэтгэлээ.

1. Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хуулийн хэрэгжилт:

Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны А/35 дугаар тушаалаар батлагдсан бараа, түүхий эдийн жагсаалт, ангилалын кодны дагуу биржийн арилжаанд бараа, түүхий эдийг оруулж байгаа бөгөөд үүнээс одоогоор 2022 оны 6 дугаар 15-ны байдлаар 84 удаагийн арилжаа зохион байгуулж 635 хэлцлээр 5,128 тонн ноолуур, 6,047 тонн хонины ноос, 1,048 тонн тэмээний ноос, 1,688 тонн ямааны завод ноос, 1000 тонн тосны ургамал /рапс/ тус тус арилжиж нийт 722 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй арилжаа зохион байгуулсан байна.

2. Биржээр арилжсаныг нотлох тодорхойлолт олгохтой холбоотой тодорхойлолтын хүсэлт хүлээн авах, тодорхойлолтыг олгох, дахин олгох, хүчингүй болгох талаар:

2021 оны 6 дугаар сараас 2022 оны 6 сар хүртэл арилжааны мэргэжилтэн Төлөвлөлт, мониторингийн мэргэжилтнээс нийт 1500 ширхэг тодорхойлолтын маягт хүлээн авч 1192 ширхэг тодорхойлолт бичсэн, 205 ширхэг тодорхойлолт гүйцэтгэх захирал солигдсоны улмаас хүчингүй болсон мөн 5 ширхэг тодорхойлолтын маягт техникийн алдаанаас болж хүчингүй болсон байна 179 ширхэг тодорхойлолтын маягтын үлдэгдэлтэй байна.

Тодорхойлолтын маягтын бүртгэл

ОГНОО	олгосон		зарцуулсан		Хүчингүй болсон		Эцсийн үлдэгдэл
	дугаар	ширхэг	дугаар	ширхэг	дугаар	ширхэг	ширхэг
2021.07.29	8820-8919	100	8820-8919	100			
2021.10.14	8920-9019	100	8920-9019	100			
2021.12.13	9020-9119	100	9020-9119	100			
2022.01.20	9120-9219	100	9120-9215	96	9216-9219	4	
2022.03.03	9220-9419	200			9220-9419	200	
2022.03.10	9420-9519	100	9420-9519	99	9484	1	
2022.05.10	9520-9619	100	9520-9619	99	9603	1	
2022.05.12	9620-9719	100	9620-9719	100			
2022.05.27	9820-9919	100	9820-9919	99	9870	1	
2022.06.15	9920-10019	100	9920-10019	99		1	
2022.06.22	10020-10119	100	10020-10119	100	10118	1	
2022.06.27	10120-10319	200	10120-10319	199	10122	1	79
2022.07.01	10320-10419	100					100
		1500		1192		210	179

3. Тодорхойлолтын хяналтын картыг үнэн зөв хөтөлж байгаа, эсэх хураамжийг цаг тухайд нь төлүүлж байгаа талаар:

2021 оны 6 дугаар сараас 2022 оны 6 дугаар сар хүртэл олгогдсон тодорхойлолтын хяналтын картыг сар тус бүрээр дугаараар нь тулгаж, үнэн зөв хөтөлсөн эсэхийг шалгав.

2021 оны 6 сар 8576 -8794 дугаартай 219 ширхэг тодорхойлолт, хяналтын картыг зөв хөтөлсөн байна.

2021 оны 7 сар 8795-8825 дугаартай 31 ширхэг тодорхойлолт хяналтын картыг зөв хөтөлсөн байна.

2021 оны 8 сар 8826-8854 дугаартай 29 ширхэг тодорхойлолт хяналтын картыг зөв хөтөлсөн байна.

2021 оны 9 сар 8855-8870 дугаартай 18 ширхэг тодорхойлолт хяналтын картыг зөв хөтөлсөн байна.

2021 оны 10 сар 8872-8909 дугаартай 38 ширхэг тодорхойлолт, **10 дугаар сарын 21-нээс хойш хяналтын картууд гарын үсэг байхгүй, өөрөөр хэлбэл хяналт хийгдээгүй олгогдсон байна.** /8871 тодорхойлолтыг устгалд оруулж 8868 дугаараар олгосон/

2021 оны 11 сар 8910-8955 дугаартай 46 ширхэг тодорхойлолт **хяналт хийгдээгүй, хяналтын карт гарын үсэггүй олгогдсон байна.**

2021 оны 12 сар 8956-9087 дугаартай 132 ширхэг тодорхойлолт **хяналт хийгдээгүй, хяналтын карт гарын үсэггүй олгогдсон байна.**

2022 оны 1 сар 9088-9157 дугаартай 70 ширхэг тодорхойлолт 1 сарын 11-нээс 31 хүртэл **хяналт хийгдээгүй, хяналтын карт гарын үсэггүй олгогдсон байна.**

2022 оны 2 сар 9158-9200 дугаартай 43 ширхэг тодорхойлолт, хяналтын картыг зөв хөтөлсөн байна.

2022 оны 3 сар 9201-9427 дугаартай 227 ширхэг тодорхойлолт, хяналтын картыг зөв хөтөлсөн байна.

2022 оны 4 сар 9428-9472 дугаартай 45 ширхэг тодорхойлолт, хяналтын картыг зөв хөтөлсөн байна.

2022 оны 5 сар 9473-9868 дугаартай 396 ширхэг тодорхойлолт, хяналтын картыг зөв хөтөлсөн байна.

2022 оны 6 сар 9869-10181 дугаартай 313 ширхэг тодорхойлолт, хяналтын картыг зөв хөтөлсөн байна.

Тодорхойлолтын хураамж яаралтай 10.000 төгрөг энгийн 5000 төгрөг цаг хугацаандаа үнэн зөв төлөгдсөн байна.

Түүврийн аргыг хэрэглэн дараахь асуудлуудад хяналт, мониторинг хийсэн болно.

Тухайлбал: 2021 оны 6 дугаар сараас 2022 оны 6 дугаар сар хүртэл сар бүрийн нэг өдрийг сонгож тухайн өдөр олгосон тодорхойлолтонд

- **Бараа түүхий эдийн нэр төрөл, ангилал, боловсруулалт, хэмжээ болон үнийн мэдээллийг үнэн зөв тусгаж байгаа, эсэх;**
- **Биржээр арилжсан боловсруулаагүй бараа түүхий эдийн ангилал өөрчлөн тодорхойлолт олгохдоо, боловсруулсан бараа түүхий эдийн ангилалд хөрвүүлэх хувийг зөв тооцоолж байгаа, эсэх;**

- **Тодорхойлолтын хүчинтэй хугацааг мөрдөж байгаа,эсэхийг** нэг бүрчлэн шалгаж, программын тодорхойлолт олгосон дататай тулгаж үзэв.

2021 оны 6 дугаар сарын 29

8862-8872 дугаартай 11 ширхэг тодорхойлолт олгогдсон

8862-8869 дугаартай 8 ширхэг тодорхойлолт буцаагдсан

8870 дугаартай тодорхойлолт хонины ноос 29400 кг

8871 боловсруулаагүй цайвар ноолуур түүхий ноолуурын хэмжээ 11920 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 8344 кг

8872 боловсруулаагүй цайвар ноолуур түүхий ноолуурын хэмжээ 5110 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 3577 кг

2021 оны 7 дугаар сарын 22

8805-8810 дугаартай 6 ширхэг тодорхойлолт олгогдсон

8805-8806 дугаартай 2 ширхэг тодорхойлолт буцаагдсан

8807 боловсруулаагүй бараан ноолуур 14047 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 7023,6 кг

8808 боловсруулаагүй бараан ноолуур 18758 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 4289,1 кг

8809 хонины ноос угаасан 28150 кг

8810 хонины ноос угаасан 28200 кг

2021 оны 8 дугаар сарын 03

8826-8829 дугаартай 4 ширхэг тодорхойлолт олгогдсон

8826 хонины ноос 25000 кг

8827 хонины ноос 25000 кг

8828 хонины ноос 25000 кг

8829 тэмээний ноос 26000 кг бүгд буцаагдсан

2021 оны 9 дугаар сарын 15

8859-8862 дугаартай 4 ширхэг тодорхойлолт олгогдсон

8859 боловсруулаагүй бараан ноолуур 12201 кг

8860 боловсруулаагүй бараан ноолуур 4101 кг

8861 боловсруулаагүй бараан ноолуур 8164 кг

8862 боловсруулаагүй бараан ноолуур 8425 кг бүгд буцаагдсан

2021 оны 10 дугаар сарын 27

8904-8909 дугаартай 6 ширхэг тодорхойлолт олгогдсон

8904 боловсруулаагүй цайвар 7179 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 5025 кг
8905 боловсруулаагүй цайвар 17980 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 12586 кг
8906 боловсруулаагүй цайвар 11467 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 8027,2 кг
8907 боловсруулаагүй цайвар 1537 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 1076,2 кг
8908 боловсруулаагүй цайвар 9146 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 6402,4 кг
8904 боловсруулаагүй цайвар 1349 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 944,6 кг

2021 оны 11 дугаар сарын 01

8910-8915 дугаартай 6 ширхэг тодорхойлолт олгогдсон

8910 боловсруулаагүй бараан ноолуур 12820 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 8974,2 кг
8911 боловсруулаагүй бараан ноолуур 7967 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 5588,2 кг
8912 боловсруулаагүй цайвар ноолуур 15087 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 10560,8 кг
8913 боловсруулаагүй бараан ноолуур 21867 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 15306,6 кг
8914 боловсруулаагүй бараан ноолуур 8245 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 5771,4 кг
8915 боловсруулаагүй бараан ноолуур 18348 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 12843,4 кг

2021 оны 12 дугаар сарын 13

9014-9015 дугаартай 2 ширхэг тодорхойлолт олгогдсон

9014 угаасан цайвар бараан ноолуур 12820 кг
9015 боловсруулаагүй бараан ноолуур 8256 кг

2022 оны 1 дугаар сарын 11

9092 дугаартай 1 ш тодорхойлолт олгогдсон

9092 боловсруулаагүй бараан ноолуур 28514 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 9960 кг

2022 оны 2 дүгээр сарын 22

9184 дугаартай 1 ш тодорхойлолт олгогдсон

9184 боловсруулаагүй бараан ноолуур 16950 кг самнасанд хөрвүүлсэн хэмжээ 8475 кг

2022 оны 3 дүгээр сарын 01

9201-9205 дугаартай 5 ш тодорхойлолт олгогдсон

9201 тэмээний ноос 25300 кг

9202 тэмээний ноос 23300 кг

9203 тэмээний ноос 21150 кг

9204 тэмээний ноос 16182 кг

9205 хонины ноос 9205 кг

2022 оны 4 дүгээр сарын 20

9448-9458 дугаартай 11 ш тодорхойлолт олгогдсон

9448 боловсруулаагүй цайвар ноолуур 20017 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 14011,8 кг

9449 боловсруулаагүй цайвар ноолуур 7964 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 5574,6 кг

94450 боловсруулаагүй цайвар ноолуур 5360 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 3752 кг

9451 боловсруулаагүй бараан ноолуур 21420 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 14994 кг

9452 боловсруулаагүй цайвар ноолуур 22436 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 15705,2 кг

9453 боловсруулаагүй цайвар ноолуур 4322 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 3025,7 кг

9454 боловсруулаагүй бараан ноолуур 21723 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 15206,2 кг

9455 боловсруулаагүй бараан ноолуур 5030 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 3521,2 кг

9456 боловсруулаагүй цайвар ноолуур 21750 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 15224,9 кг

9457 боловсруулаагүй бараан ноолуур 7630 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 5340,8 кг

9458 боловсруулаагүй бараан ноолуур 4828 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 3379,4 кг

2022 оны 5 дугаар сарын 24

9785-9794 дугаартай 10 ш тодорхойлолт олгогдсон

9785 боловсруулаагүй цайвар ноолуур 33600 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 18800 кг

9786 Завод ноос 8000 кг

9787 Завод ноос 16000 кг

9788 Хонины ноос 24700 кг

9789 Хонины ноос 24660 кг

9790 Хонины ноос 24630 кг

9791 Хонины ноос 24570 кг

9792 Хонины ноос 24550 кг

9793 Хонины ноос 24500 кг

9794 Хонины ноос 21850 кг

2022 оны 6 дүгээр сарын 10

9981-9993 дугаартай 13 ш тодорхойлолт олгогдсон

9981 боловсруулаагүй цайвар ноолуур 9838 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 4918,8 кг

9982 боловсруулаагүй бараан ноолуур 9544 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 4772,1 кг

9983 боловсруулаагүй цайвар ноолуур 8917 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 4458,4,8 кг

9984 боловсруулаагүй бараан ноолуур 1111 кг угаасанд хөрвүүлсэн хэмжээ 555,7 кг

9985 Хонины ноос 24730 кг

9986 Хонины ноос 24730 кг

9987 Хонины ноос 24730 кг

9988 Хонины ноос 24730 кг

9989 Хонины ноос 24440 кг

9990 Хонины ноос 24400 кг

9991 Хонины ноос 24440 кг

9992 Хонины ноос 24440 кг

9993 Хонины ноос 24440 кг

- 2021 оны 6 дугаар сараас 2022 оны 6 дугаар сар хүртэл олгосон тодорхойлолтонд бараа түүхий эдийн нэр төрөл, ангилал, боловсруулалтын мэдээллийг үнэн зөв тусгаж, боловсруулсан бараа түүхий эдийн ангилалд хөрвүүлэх хувийг зөв тооцоолж /программаар тооцоолдог/ тодорхойлолтын хүчинтэй хугацааг мөрдөж ажилласан байна.

- Харин блокчэйн программ нь тодорхойлолтын үнийн дүнг буруу аргачлалаар бодсоноос шалтгаалан тодорхойлолтын үнийн дүн программ дээр буруу тавигдаж байна.

- 2021 онд цар тахлийн улмаас хил гааль хаалттай байсан тул маш олон тодорхойлолт буцаагдсан байна. Олгогдсон тодорхойлолт нь 10 хоногийн хүчинтэй хугацаа дуусаад 1-3 сар болсоны дараа харилцагчид ноолуур экспортонд гаргах боломжтой болсон үедээ тодорхойлолт буцаах өргөдлөө өгсөн байна.

- Арилжааны үе, өмнө болон дараа цахимаар ямар ч хяналт шалгалт хийгддэггүй юм байна. Өөрөөр хэлбэл Цахим хөгжүүлэлт, арилжааны хяналтын хэлтэс нь хяналтын үйл ажиллагаа эрхэлдэггүй юм байна.

4. Тодорхойлолтыг журмын дагуу олгож байгаа эсэхэд хяналт хийх зорилгоор арилжааны өмнөх, арилжааны үеийн, арилжааны дараахь хяналтууд хийгдэж байгаа, эсэх;

2021 оны 6 дугаар сараас 2022 оны 6 дугаар хүртэл төлбөр тооцооны баримт материал, гүйлгээний жагсаалт, биелсэн гэрээний мэдээ, хэлцлийн мэдээг бүх сарын долоо долоо хоногоор багцалсан баримтуудыг нэг бүрчлэн тулгаж шалгав.

Төлбөр тооцоо эрсдлийг удирдлагын хэлтсийн биелсэн гэрээний дүн, Арилжаа зах зээл хөгжүүлэлтийн хэлтсийн хэлцлийн мэдээний дүн 2-ыг тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй баримт байгаагүй болно.

Арилжааны өмнө ТТЭУХ-г дэнчин барьцаа хөрөнгүүд цаг хугацаандаа тавигдаж, дэнчин барьцаа хөрөнгийн буцаалтууд үнэн зөв хийгдсэн байна.

2021 оны 6 дугаар сараас 2022 оны 6 дугаар сар хүртэл итгэмжлэгдсэн агуулахаас арилжаанд орсон самнасан ноолуурыг шалгасан тухай.

Д/д	Он сар өдөр	Агуулахын нэр	Бараа, түүхий эдийн нэр	Хэмжээ /кг/	Тайлбар
1	2021.3.5	Лоро Пьяана ХХК	Самнасан ноолуур	12.100	Биет хяналт шалгалт хийж илтгэх хуудас бичсэн
2	2021.3.6	Монитал кашимер ХХК	Самнасан ноолуур	10.000	Биет хяналт шалгалт хийж илтгэх хуудас бичсэн
3	2021.6.21-25	Монитал Кашемир ХХК	Самнасан ноолуур	2.926	Агуулахын бүх үлдэгдэлээс хасч тооцов
4	2021.07.29	Их зам транс ХХК	Самнасан ноолуур	1.196	Утсаар холбогдсон
5	2021.8.3	Их зам транс ХХК	Самнасан ноолуур	1.271	Утсаар холбогдсон
6	2021.8.18	Монитал кашимер ХХК	Самнасан ноолуур	347	Агуулахын бүх үлдэгдэлээс хасч тооцов
7	2021.9.6	Өгөөж Шим ХХК	Самнасан ноолуур	400	Биет хяналт шалгалт хийв
8	2021.11.15	Монитал кашимер ХХК	Самнасан ноолуур	307	Агуулахын бүх үлдэгдэлээс хасч тооцов
9	2021.11.19	Тогтвортой ноолуурын холбоо	Самнасан ноолуур	30	
10	2022.02.22	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	Агуулахын бүх үлдэгдэлээс хасч тооцов
11	2022.3.23	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	2.200	Биет шалгалт хийж агуулах дахь бүх үлдэгдэлийг тоолон хасалт хийхээр болсон.
12	2022.4.1	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	1.700	Агуулахын эцсийн үлдэгдэлээс хасч тооцов
13	2022.4.1	Баялаг Гүрэм хоршоо	Самнасан ноолуур	100	
14	2022.4.1	Өгөөж Шим ХХК	Самнасан ноолуур	200	Биет хяналт шалгалт хийсэн
15	2022.4.6	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	3.000	Агуулахын эцсийн үлдэгдэлээс хасч тооцов
16	2022.4.11	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	900	Агуулахын эцсийн үлдэгдэлээс хасч тооцов

17	2022.4.21	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	300	Агуулахын эцсийн үлдэгдэлээс хасч тооцов
18	2022.4.20	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	3.364	Агуулахын эцсийн үлдэгдэлээс хасч тооцов
19	2022.4.25	Эм Кэй Вай ХХК	Самнасан ноолуур	2.016	Утсаар ярьж холбогдож баталгаажуулсан
20	2022.5.3	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	3.600	Агуулахын эцсийн үлдэгдэлээс хасч тооцов
21	2022.5.10	Эм Кэй Вай ХХК	Самнасан ноолуур	243	Утсаар холбогдож баталгаажуулсан
22	2022.5.13	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	4.000	Агуулахын эцсийн үлдэгдэлээс хасч тооцов
23	2022.5.17	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	670	Агуулахын эцсийн үлдэгдэлээс хасч тооцов
24	2022.5.18	Жин Корона	Самнасан ноолуур	1.200	Биет хяналт шалгалт хийв
25	2022.5.18	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	240	Агуулахын эцсийн үлдэгдэлээс хасч тооцов
26	2022.5.20	Эм Кэй Вай кашимер	Самнасан ноолуур	2.142	Биет хяналт шалгалт хийсэн
27	2022.5.25	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	11.267	Биет хяналт шалгалт хийсэн
28	2022.5.26	Өгөөж Шим ХХК	Самнасан ноолуур	99	Утсаар ярьж агуулахын эцсийн үлдэгдэлээр хянасан
29	2022.6.2	Эм Кэй Вай кашимер ХХК	Самнасан ноолуур	2.016	Агуулахын эцсийн үлдэгдэлээс хасч тооцов
30	2022.6.13	Эм Кэй Вай кашимер ХХК	Самнасан ноолуур	1.800	Биет хяналт шалгалт хийв
31	2022.6.13	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	3.100	Агуулахын эцсийн үлдэгдэлээс хасч тооцов
32	2022.6.17	Монитал кашимер ХХК	Самнасан ноолуур	2.842	Агуулахын эцсийн үлдэгдэлээс тооцов
34	2022.6.17	Лоро Пьяана Монгол ХХК	Самнасан ноолуур	5.200	Биет хяналт шалгалт хийв

5. Тодорхойлолтыг үндэслэн арилжааны шимтгэлийг үнэн зөв тодорхойлох Биржийн байнгын гишүүд арилжааны шимтгэлээ хугацаанд нь төлж барагдуулж байгаа талаар:

Шимтгэл төлөлтийн мэдээлэл 2021.06.02-2021.12.31

Нийт	Нийт төлөгдсөн дүн	Төлбөр хийгдээгүй
3,780,975,884.60	2,692,903,640.80	513,398,336.20
МЭТУ	425,394,492.20	хугацаа хэтэрсэн
Бадархундага оргил	48,480,533.89	хугацаа хэтэрсэн
Хан бүргэд хэнтий	369,451,480.00	төлөгдөх хугацаандаа байгаа
Хаан тэлмэн	300,000,000.00	төлөгдөх хугацаандаа байгаа
Алтаншагай импекс	328,588,440.00	төлөгдөх хугацаандаа байгаа
Суварга алтай констракшн	88,003,844.00	төлөгдөх хугацаандаа байгаа
Цэц-инвест	2,028,480.00	төлөгдөх хугацаандаа байгаа
	1,561,947,270.09	
	1,048,548,933.89	хугацаа хэтэрсэн
	513,398,336.20	төлөгдөх хугацаандаа байгаа

Арилжаны шимтгэл төлөлтийг санхүүгийн баримттай тулгаж үзэхэд 2021 оны 6 сараас 2021 оны 12 дугаар сар хүртэл арилжааны шимтгэл төлөлт нийт төгрөг **3,780,975,884.60** төгрөгийн шимтгэл төлөлтийн орлого орсон бөгөөд 1,561,947,270.09 төгрөгийн шимтгэлийн төлбөр хугацаандаа хийгдээгүй байснаас 2022 онд нэр бүхий 5 брокерын компаниудтай шимтгэл төлөлтийн гэрээ байгуулан авлага барагдуулахаар ажиллаж байгаа бөгөөд **1,048,548,933.89** төгрөгийн шимтгэл төлөлтийн авлагыг барагдуулж төлбөр төлөлтийн хугацаа хэтэрсэн 513,398,336.20 төгрөгийн арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн авлагатай 2 компанийг шүүхэд шилжүүлсэн байна.

Шимтгэл төлөлтийн мэдээлэл 2022.01.02-2022.06.30

Нийт	Нийт төлөгдсөн дүн	Төлбөр хийгдээгүй
4,371,722,422.80	4,101,861,336.20	269,861,086.60
Хонгор арвижих	132,979.00	хугацаа хэтэрсэн
Цэц инвест	4,806,400.00	хугацаа хэтэрсэн
Алтаншагай импекс	11,283,700.00	төлөгдөх хугацаандаа байгаа
Хан бүргэд хэнтий	37,816,508.00	төлөгдөх хугацаандаа байгаа
Хаан тэлмэн	215,821,500.00	төлөгдөх хугацаандаа байгаа
	269,861,087.00	төлөгдөх хугацаандаа байгаа

2022 оны 6 дугаар сарын байдлаар 4,371,722,422.80 төгрөгийн шимтгэл төлөлтийн орлого орсон бөгөөд **269,861,086.60** төлөгдөх хугацаандаа явж байна.

Хяналт мониторингийн дүгнэлт:

1. Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хуулийн хүрээнд ХХААХҮ-ийн Сайдын баталсан жагсаалтад байгаа бараа түүхий эдийг бирж арилжаалж, тус хуулийн 4.6 заалтын дагуу экспортонд гарах бараанд тодорхойлолт олгосон байна.
2. 2021 оны 6 дугаар сараас 2022 оны 6 дугаар сар хүртэл олгосон тодорхойлолтонд бараа түүхий эдийн нэр төрөл, ангилал, боловсруулалтын мэдээллийг үнэн зөв тусгаж, боловсруулсан бараа түүхий эдийн ангилалд хөрвүүлэх хувийг зөв тооцоолж /программаар тооцоолдог/ тодорхойлолтын хүчинтэй хугацааг мөрдөж ажилласан байна.
3. “Биржээр арилжсан бараа түүхий эдийн тодорхойлолт олгох журам”-ын **3.8 Тодорхойлолт бүр хяналтын карттай байх бөгөөд хяналтын картад Хяналтын чиг үүрэг бүхий этгээд, Арилжаа хариуцсан хэлтсийн менежер гарын үсгээр баталгаажуулна** гэсэн заалтыг хангалтгүй биелүүлж ирсэн байна.

Тухайлбал: Зарим саруудад тодорхойлолтын хяналтын картыг хөтлөөгүй, өөрөөр хэлбэл 2021 оны 10 дугаар сарын 21-нээс 2022 оны 2 дугаар сарын 01-н хүртэл тодорхойлолт нь ямар нэгэн хяналт хийгдэлгүй олгогдсон байна. Энэ нь блокчэйний хяналтын програмд хянах эрх бүхий этгээдүүд нь нэвтрэх боломжгүй байсан байна.

4. Блокчэйн прорамм нь тодорхойлолтын үнийн дүнг программ дээр буруу боддог, арилжааны мэргэжилтэн гар аргаар тодорхойлолтын үнийн дүнг бодож тавьж байна.
5. **БИРЖЭЭР АРИЛЖСАН БАРАА ТҮҮХИЙ ЭДИЙН ТОДОРХОЙЛОЛТ ОЛГОХ ЖУРАМ”** -ын **5.9 Тодорхойлолт нь олгосон өдрөөс хойш 10 хоногийн хугацаанд хүчинтэй байна.** Гэтэл харилцагчид нь 1-3 сарын дараа тодорхойлолт буцаах өргөдөл өгсөн байна.
6. Биржээр арилжсан бараа түүхий эдийн тодорхойлолт олгох журам” -ын **4.2 Бирж нь тодорхойлолт хүсэгчийн ашиглах боломжгүй болсон тодорхойлолтын хувийг Гаалийн байгууллагад шуудангаар илгээж, тухайн дугаартай тодорхойлолт хүчингүй болсныг мэдэгдэнэ.** Журмын энэ заалтыг огт хэрэгжүүлдэггүй юм байна.
7. Цахим хөгжүүлэлт, арилжааны хяналтын хэлтэс нь арилжааны үе, өмнө болон дараа үед цахимаар ямар ч хяналт шалгалт хийхгүй байна.
8. Арилжааны өмнөх хяналт болох зөвхөн самнасан ноолуурын хяналтыг шалгаж үзэхэд 130 кг ноолуурыг ямар хяналт хийлгүйгээр самнасан ноолуур гэж үзэн биржийн шимтгэлгүй тодорхойлолт олгосон байна.
9. Биржийн шимтгэлийг Төлбөр тооцоо эрсдлийг удирдлагын хэлтсийн **биелсэн гэрээний дүн**, Арилжаа зах зээл хөгжүүлэлтийн хэлтсийн **хэлцлийн мэдээний дүнг** үндэслэн үнэн зөв тооцоолсон байна.
10. 2021 онд байнгын гишүүдийн төлөх арилжааны шимтгэлийн үлдэгдэл 1,561,947,270 байсан бөгөөд 2022 оны 6 сар гэхэд **1,048,548,933.89** төлөгдөж үлдэгдэл 513,398,336 одоо хүртэл төлөгдөөгүй шүүхийн шатанд явж байна. 2022 оны хувьд 269,861,086 төлөгдөөгүй байгаа бөгөөд 4,939,379 хугацаа хэтрэлттэй байна.

Хяналт мониторингийн зөвлөмж:

1. Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны А/35 дугаар тушаалын бараа түүхий эдийн жагсаалтад орсон арилжиж эхлээгүй байгаа мал, мах, арьс ширийг биржээр арилжаалж эхлэх;
2. БИРЖЭЭР АРИЛЖСАН БАРАА ТҮҮХИЙ ЭДИЙН ТОДОРХОЙЛОЛТ ОЛГОХ ЖУРАМ” -ын
2.8 Тодорхойлолт бүр хяналтын карттай байх бөгөөд хяналтын картад Хяналтын чиг үүрэг бүхий этгээд, Арилжаа хариуцсан хэлтсийн менежер гарын үсгээр баталгаажуулна
Арилжаа зах зээл хөгжүүлэлтийн хэлтэс дээрх журмын заалтыг хэрэгжүүлж ажиллах;
3. Арилжааны мэргэжилтэн гар аргаар тодорхойлолтын үнийн дүнг бодож тавьж байгаа нь өндөр эрсдлийг бий болгож байгаа тул, ЦХАХ хэлтэс нь блокчейн дээр програмаар тодорхойлолтын үнийн дүнг бодуулж, тодорхойлолтын үнийн дүнг үнэн зөв тооцоолох шаардлагатай байна;
4. БИРЖЭЭР АРИЛЖСАН БАРАА ТҮҮХИЙ ЭДИЙН ТОДОРХОЙЛОЛТ ОЛГОХ ЖУРАМ” -ын
5.9 Тодорхойлолт нь олгосон өдрөөс хойш 10 хоногийн хугацаанд хүчинтэй байна заалтын хувьд харилцагчид 10 хоногийн дотор экпортонд бараагаа гаргаагүй бол биржэд даруйхан мэдэгдэх шаардлагатай байна;
АЗЗХ хэлтэс нь Гаалийн байгууллагад хүчингүй болсон тодорхойлолтын дугаарыг илгээх шаардлагатай байна.
5. Биржээр арилжсан бараа түүхий эдийн тодорхойлолт олгох журам” -ын
4.2 Бирж нь тодорхойлолт хүсэгчийн ашиглах боломжгүй болсон тодорхойлолтын хувийг Гаалийн байгууллагад шуудангаар илгээж, тухайн дугаартай тодорхойлолт хүчингүй болсныг мэдэгдэнэ.
АЗЗХ хэлтэс эь журмын заалтыг хэрэгжүүлэх ажиллах шаардлагатай байна;
6. ЦХАХ хэлтэс нь арилжааны хяналт яаж хийх үйл ажиллагаагаа тодорхой болгон, арилжааны цахим хяналтаа хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.
7. Гишүүнчлэл бүртгэлийн хэлтэс нь арилжааны өмнөх хяналтыг тогтмол хийх, ялангуяа арилжаанд орохоос өмнө самнасан ноолуурыг агуулах дээр нь очиж, биечлэн шалган, биржийн арилжааны шимтгэлийг төлөх, эсэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.
8. Захиргаа, санхүүгийн хэлтэс нь биржийн байнгын гишүүдийн арилжааны шимтгэлийг журамд заасан хугацаанд төлүүлэх хэрэгтэй бөгөөд төлөөгүй тохиолдолд Гишүүнчлэлийн журамд заасан шат дараалсан арга хэмжээнүүдийг цаг тухайд нь хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Хяналт, мониторингын зөвлөмжийн хүрээнд хийсэн ажил, үр дүнгийн тайланг 2022 оны 9 дүгээр сарын 01-нээс өмнө Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн О.Сайнжаргал-д илгээнэ үү.

Хяналт мониторинг хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан:
Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

О.Сайнжаргал

Хяналт мониторинг хийж, тайлан боловсруулсан:
Төлөвлөлт, мониторингын мэргэжилтэн

Х.Наранцацралт

Хяналт мониторингын ажлын тайлан, дүгнэлт, зөвлөмжтэй танилцсан:

Захиргаа, санхүүгийн хэлтсийн менежер

Б.Саруул;

Арилжаа, зах зээл хөгжүүлэлтийн
хэлтсийн менежер

Р.Ариунбат;

Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын
хэлтсийн менежер

Х.Оргил;

Цахим хөгжүүлэлт, арилжааны хяналтын
хэлтсийн менежер

А.Дөлгөөн;

Гишүүнчлэл, бүртгэлийн хэлтсийн менежер

Б.Гантөмөр;

Ерөнхий нягтлан бодогч

Б.Номин-Эрдэнэ.